

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 26 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны аравдугаар сарын 1-ний өдрийн 9 цаг 07 минутад эхэлж, 10 цаг 27 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь Салбар зөвлөлийн 2014 оны 63 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Очирхуягийн Батчимэгийг 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 8-д “...Засаг даргын Тамгын газрын дарга Сүрэнжавын Бөххүү ” гэсний дараа “Нарийн бичгийн дарга-аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Очирхуягийн Батчимэгийг” гэж нэмэх.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга О.Батчимэгт үүрэг</p>

		болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтаас хасах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 160 дугаар тогтоолын 3, 9 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 160 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "7; Мэргэжлийн хяналтын газар; Улсын байцаагч; Боловсрол, соёл урлагийн хяналт шалгалт; Дэс түшмэл ТЗ-6" гэсний "Батчулуун Нарантуяа; 64.8" мөн тогтоолын 9 дүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "6; Мэргэжлийн хяналтын газар; Улсын байцаагч; Боловсрол, соёл урлагийн хяналт шалгалт; Дэс түшмэл ТЗ-6" гэсний "Батчулуун Нарантуяа; 64.8" гэсэн хэсгийг тус тус хасах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2014 оны 05 дугаар сарын</p>

		<p>05-ны өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 53 дугаар тогтоолын 1,2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 53 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "16; Гэр хорооллын хөгжлийн газар; Мэргэжилтэн; Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх талаар гарсан хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Ганхуяг Ганбаяр; 82.66" мөн тогтоолын 2 дугаар хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "7; Гэр хорооллын хөгжлийн газар; Мэргэжилтэн; Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх талаар гарсан хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх; Дэс түшмэл ТЗ-5" гэсний "Ганхуяг Ганбаяр; 82.66" гэсэн хэсгийг тус тус хасах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан тушаалд нэр дэвшигч Ц.Ширэндэвийг нөөцөөс хасах тухай</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.1.6 дахь заалт, иргэн Ц.Ширэндэвийн гаргасан хүсэлтийг тус тус баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Тусгай хамгаалалттай нутгийн захиргааны газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны</p>

		<p>нөөцийн жагсаалтаас иргэн Цанжидын Ширэндэвийг хассанд тооцох.</p> <p>2.Энэ тогтоолыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон иргэн Ц.Ширэндэв нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Өмнөговь, Дундговь, Баян-Өлгий, Дорноговь, Говьсүмбэр, Баянхонгор, Өвөрхангай дахь Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж өгсөн тухай тайлан сонсох</p>	<p>Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Баян-Өлгий, Баянхонгор Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах явцад гарсан зөрчлүүдийг арилгах талаар зөвлөмж өгч, тайланг 2014 оны 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх үүрэг болгов.</p> <p>Тайланг нэгтгэх, УИХ, Засгийн газар, холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулахад бэлтгэх,</p> <p>Бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг боловсронгуй болгож, онлайнаар төрийн албан хаагчид мэдээллээ оруулах боломжийг судлах нь зүйтэй гэж үзэв.</p>
5	<p>Бусад асуудал /Дорнод аймгийн Засаг даргын орлогч М.Бадамсүрэнгээс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай/</p>	<p>Дорнод аймгийн Засаг даргын орлогч М.Бадамсүрэнгийн “Хүсэлт тавих тухай” 2014 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 1/3487 тоот албан бичиг, хүсэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар 16.3-т заасныг үндэслэл болгон:</p> <p>Дорнод аймгийн Засаг даргын “Д.Ганбаярыг ажилд томилох тухай” 2013 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Б/40 дүгээр захирамжаар Зүүн бүсийн Зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын албан тушаалд Д.Ганбаярыг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг зөрчсөн байх тул захирамжийг хүчингүйд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ